

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ Т.БОЛОРЧИМЭГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
- Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, тэтгэмж, урамшууллын бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, тооцоо, судалгааны нэгтгэл хийх, тайлагнах							
1.	Арга хэмжээ 1.1 Эрүүл мэндийн салбарын цалин хөлстэй холбоотой холбогдох тооцоо, судалгаа хийх, шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулах	Тооцоо, судалгаа	-	Судалгаа хийгдэж санал боловсруулсан байна	- Төрийн үйлчилгээний салбарын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор баталсан ба “эмнэлгийн физикч”, “туяа эмчилгээний техникч” нарын албан тушаал нь жагсаалтад байдаггүй тул “эмнэлгийн физикч” албан тушаалыг ТҮЭМ-7 ангилалд; “туяа эмчилгээний техникч” албан тушаалыг ТҮЭМ-5 ангилалд шинээр нэмж оруулахаар холбогдох үндэслэл, тооцоог боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн	2025.01.01 2025.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлти йн хувь
	1	2	3	4	5	6	7
					хамгааллын яаманд 2025.04.15-ны 1а/1852 тоотой санал хүргүүлсэн. - Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан ба Аймгийн Эрүүл мэндийн газрын “Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн”-ний албан тушаалыг ТЗ-9 ангиллаас өөрчилж ТЗ-7 ангилалд оруулахаар холбогдох үндэслэл, тооцоог боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025.04.15-ны 1а/1852 тоотой санал хүргүүлсэн.		
					- Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын хэлэлцээр”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоол, 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/544 дүгээр тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаал зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					эрх зүйн баримт бичгийг баримтлан ажиллах тухай чиглэл, зөвлөмжийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 2025.04.29-ны 1а/2171 тоотойр хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт боловсруулж батлуулна	Шалгуур үзүүлэлт	-	Шалгуур үзүүлэлт боловсруулж, санал авсан байна	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалтын дагуу Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг СТГ-ын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтэстэй хамтран боловсруулж, ТНБД-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн сайдын тушаалд санал авах хуудас”-ын дагуу 7 газар, 2 хэлтэс болон ТНБД-аас санал аваад байна. Шалгуурыг Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн болон эмнэлгийн бусад мэргэжилтэн гэсэн ангиллаар тус бүрт нь 6-8 шалгуур үзүүлэлт байхаар боловсруулсан болно.	2024.01.01 2024.06.30	100
3.	Арга хэмжээ 1.3. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд олгох мөнгөн тэтгэмжийн нэгдсэн мэдээлэл, зохион	Мөнгөн тэтгэмж	-		2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 заалтын дагуу эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 3,8 тэрбум төгрөг, харин хуулийн 29.5 дахь заалтын дагуу Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	байгуулалтаар хангах				болон Аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа албан хаагчдад 7,2 тэрбум төгрөгийг олгоод байна. Мөн хөдөө орон нутгаас болон нийслэл дүүргийн ирсэн 8 албан хаагчид тэтгэмжийн тухай зөвлөмж өгч ажилласан байна.		
Зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, холбогдох тооцоолол, судалгаа хийх							
2.1	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, журманд дүн шинжилгээ хийж шинэчлэх	Тусламж үйлчилгээн ий жагсаалт		Шинэчлэн боловсруулж санал авсан байна	“Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-ыг үндэслэн "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-г ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор шинэчлэн тусламж, үйлчилгээний багцад өөрчлөлт орсон тул үүнтэй уялдуулан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн боловсруулав. Жагсаалтыг төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд болон Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч судлан дүн шинжилгээ хийсэн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалаар 866 тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэхээр батлагдсан бол шинэчилсэн жагсаалтаар 1287 байхаар боловсруулсан. Шинэчилсэн жагсаалт, журманд	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
					ТНБД-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн сайдын тушаалд санал авах хуудас”-ын дагуу 7 газар, 2 хэлтсээс болон ТНБД-аас санал аваад байна.		
2.2	Арга хэмжээ 2.2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ, журмыг шинэчлэх	Эрүүл мэндийн сайдын тушаал		Шинэчлэн боловсруулж санал авсан байна	“Эрүүл мэндийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дахь заалтыг үндэслэн Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ, журмыг шинэчлэн боловсруулж, ТНБД-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн сайдын тушаалд санал авах хуудас”-ын дагуу 7 газар, 2 хэлтсээс санал аваад байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнэ тарифт тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээний өсөлт, эмнэлгүүдийн хүчин чадлын өсөлт, жил бүр салбарт нийлүүлэгдэж буй хүний нөөцийн өсөлт, зах зээл дэх бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинэчлэгдсэн, төрийн албан хаагчдын цалингийн болон тэтгэвэр тэтгэмжийн өсөлт зэргийн нөлөөллийг тооцон боловсруулсан болно.	2024.01.01 2024.06.30	100
Зорилт 3. Бодлогын баримт бичгүүд болон Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх тайлагнах							
	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл	Нэгтгэл тайлан		Арга хэмжээний нэгтгэл	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1	ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх, тайлагнах			холбогдох газарт хүргэгдсэн байна	санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, даатгалын сангаас олгох хөнгөлөлттэй эмийн мэдээлэл, даатгалын сангийн зарцуулалтыг оновчтой болгох зэрэг чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний тайланг гаргаж ХШҮДАГ-т хүргүүлэв.		
	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх тайлагнах	Нэгтгэл тайлан		Арга хэмжээний нэгтгэл холбогдох газарт хүргэгдсэн байна	ХШҮДАГ-с ирүүлсэн Дотоод меморандум №235-ын дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан санхүү. Эдийн засгийн чиглэлийн зорилтыг тайлагнан холбогдох мэргэжилтэнд хүргүүлэв. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний өртөг, төлбөрийн аргыг боловсронгуй болгох чиглэлээр: “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох,	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					санхүүжүүлэх журам"-ыг тус тус шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлан 2025 оны 01 дүгээр сараас хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2-т заасан иргэдийн сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 2 хувь байхаар; харин Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-д заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тооцоо хийн, төсөл боловсруулж, Засгийн газрын 2025.01.02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлуулан, мөрдөж эхлээд байна.		
	Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх тайлагнах	Нэгтгэл тайлан		Арга хэмжээний нэгтгэл холбогдох газарт хүргэгдсэн байна	Эрүүл мэндийн яамны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Санхүү, даатгалын хэлтсийн хариуцан гүйцэтгэх эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээр тусгагдсан арга хэмжээ тус бүрийг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж, ТЗУГ-т болон ХШҮДАГ-т хүргүүлэв.	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.							
	Арга хэмжээ 4.1. Хариуцсан асуудлаарх албан бичиг, өргөдөл гомдлыг судлан шийдвэрлэх, хариу хүргүүлэх	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо			Хариуцсан асуудлаар 149 албан бичиг, 3 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, хариу хүргүүлсэн байна. Үүнд, бусад яамд болон ЗГХЭГ-аас ирүүлсэн Засгийн газрын 21 тогтоолын төсөл болон хуулийн 3 төсөл, бусад яамд байгууллагад 4 тайлан хүргүүлсэн байна.	2024.01.01 2024.06.30	100
	Арга хэмжээ 4.2. Хариуцсан асуудлаарх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг бэлтгэж тогтоосон хугацаанд нь холбогдох нэгж болон албан тушаалтанд хүргүүлэх.				2025 оны эхний хагас жилд дараах бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлан мэдээг бэлтгэн холбогдох байгууллага болон Эрүүл мэндийн яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн байна. Үүнд: - Үндэсний аудитын газарт Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой 2023, 2024 оны үнэлгээний тайланг хүргүүлсэн. 2025.02.11-ний 7/769 тоот - ТЗУГ-с ирүүлсэн Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөлд санал боловсруулж Дотоод мемо №216-аар хүргүүлсэн. - Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан санхүү. Эдийн засгийн чиглэлийн зорилт, арга хэмжээг тайлагнан ХШҮДАГ-т хүргүүлэв. - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2024.01.01 2024.06.30	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж ХШҮДАГ-т хүргүүлэв. - Эрүүл мэндийн яамны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Санхүү, даатгалын чиглэлийн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж ТЗУГ-т хүргүүлэв.		

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
2.	Эрүүл мэндийн сайдын зөвлөх: “Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмнэлгийн санхүүгийн удирдлага” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах	Хэлэлцүүлэг зохион байгуулах	-	Эмнэлгүүдийн оролцоог хангаж, зохион байгуулсан байна.	“Эрүүл мэндийн салбарын санхүүжилт, эмнэлгийн санхүүгийн удирдлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт харьяа байгууллагууд, 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газрууд болон Санхүү эдийн засгийн их сургууль зэрэг 51 байгууллагын 127 хүн оролцож Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, эх үүсвэр, ЭМД-ын сангийн өнөөгийн нөхцөл байдал, өртгийн удирдлага болон ДЭМБ-аас хийсэн судалгааны дүнг хэлэлцүүллээ.	2025.05.01 2025.06.15	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчид зориулсан цахим сургалтад хамрагдах	Сургалт		Сургалтад хамрагдсан байна.	Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” сургалтанд хамрагдаж №723140 тоот сертификат авсан. Сургалтаар Ёс зүй ба ёс суртахууны тухай, үнэ цэнэ, ач холбогдол; Ёс зүйн эргэлзээтэй байдал, шийдвэрлэх арга зам; Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага зэрэг хичээлийг судалсан болно.	2024.03.01 2024.07.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

СДХ Шинжигэ.....
(Албан тушаал)

Т.Болорчимэг / Бул /
(Нэр, гарын үсэг)

2025.06.10-ны өдөр
(Огноо)



УДИРДАЛГЫН
АКАДЕМИ

ҮНЭМЛЭХ

№ 723140

Таазан

овогтой Болорчимэг

Төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” анхан шат

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ
ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

Д.СҮРЭНЧИМЭГ

Доктор, дэд профессор
Удирдлагын академийн
захирал

Д.БАЙГАЛ

Доктор, профессор
Удирдлагын академийн
Төрийн албаны сургуулийн захирал

2025.5

